



## ЯЛАЛТЫН ПАРАД КОМАНДЛАГЧ

Л.Батболд хурандаа бас нэгэн бахархам үйл явдлын эзэн. Аугаа их Ялалтын 70 жилийн ойн парадад эх орны төлөөлөн Улаан талбайд жагсаж байв. Монголын цэргийн хайрцагийг командлан оролцоно гэдэг цэргийн хүн бүхний мөрөөдөл билээ. Тэр ч мөрөөдлөө биелүүлж чадсан. Ялалтын парадад 70 гаруй монгол цэргийн алба хаагч оролцож эх орныхоо нүүр царай болж байв. Хоёр сарын хугацаанд бэлтгэл хангаж, тэсвэр хатуужлийн бүхий л шалгуурыг давж, тэрхүү парадад оролцсон байдаг. Өглөө бүр гүйнэ. Талбай дээр хоёр цагаар номхон зогсооно. Хөлнөөс нь элс дүүжилж алхуулна. Хөлийг нь тэгшлэхийг тулд хөзөр хүртэл хавчуулж зогсоодог байсан гэдэг. Нисэхийн 337 дугаар ангид нэг км газар хөл тавин алхана. Энэ бүх шалгуурын дараа Монгол цэргүүд Улаан талбайг зорьсон. Тэнд монгол цэргүүд хэн гэдгээ харуулж, эх орноо дэлхийн улс оронд зарлан тунхаглаж чадсан. Энэ л үйл явдлыг бүтээгчдийн нэг нь Л.Батболд билээ. Тэрээр “Олон улс Л.Батболд командалж байна гэж харахгүй, Монгол Улсын дайчид алхаж байна гэж харах учраас бид хичээсэн. Ямартаа ч эх орон, БХЯ, ЗХЖШ–ын удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг амжилттай биелүүлсэндээ манай дайчид одоо ч гэсэн баяртай явдаг юм. Бид омогших түүхтэй өвөг дээдсийн үргэлжлэл. Тэр дайчин удмын үргэлжлэл өнөө ч дайчин чанараа алдалгүй цог хийморь, хүч төгөлдөр гэдгээ олон улсад харуулж чадсан нь бидний амжилт, нэр төрийн хэрэг. Найман зууны өмнө Чингис хааны эзэлж явсан талбайд алхаж явна гэж бодохоор бахархаад л байдаг юм билээ. Чингис хааныг их бодож омогшиж байлаа. Парадад оролцсон бүх л хүмүүс чармайж, нэгэн зүгт нэгэн зүйлийн төлөө зүтгэж байсан. Улаан талбайн жагсаал миний мөрөөдөл байсан” гэв. Улаан талбайн жагсаалд Энэтхэг улсын араас манай дайчид жагсан орж ирж, монгол түмэн бахархан омогшиж байсан цаг саяхан билээ. Ингэж Л.Батболд хурандаа монголын цэргийн түүхийн нэгэн хуудаснаа нэрээ үлдээсэн байдаг.